



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453317, Цахим хаяг: namjilt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

МАЛЧИН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ДЭЖИДМАА ТАНАА

2026.02.12 № УВА-2026/172/НА-СТА-ТЦУ?
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050210

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>140,884,314.10</u>	<u>149,093,595.90</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	89,340,793,79	40,471,912,77
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	89,340,793,79	40,471,912,77
31210	Төгрөг	89,340,793,79	40,471,912,77
31211	Төрийн сангийн харилцах	89,340,793,79	40,471,912,77
33	Авлага	0,00	479,567.22
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	0,00	479,567.22
35	БАРАА МАТЕРИАЛ	51,543,520.31	108,142,115.91
354	Хангамжийн материал	51,543,520.31	104,671,615.91
35420	Аж ахуйн материал	44,016,549.71	95,637,617.71
35430	Хүнсний материал	1,846,640.00	825,400.00
35470	Бусад хангамжийн материал	5,680,330.60	8,208,598.20
35600	Биологийн хөрөнгө		3,470,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,266,198,964.17</u>	<u>1,287,355,760.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,266,198,964.17	1,287,355,760.00
392	Биет хөрөнгө	1,218,900,964.17	1,230,057,760.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,847,647,592.00	1,417,522,592.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-830,471,313.41	-478,976,474.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,027,800.00	42,027,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,124,556.49	-42,027,800.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	271,656,568.00	312,653,548.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-182,761,254.11	-181,591,397.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,359,971.00	263,532,372.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-157,751,180.62	-152,968,424.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,138,334.00	63,138,334.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-26,275,558.55	-35,707,352.03
39217	Номын фонд	22,454,562.35	22,454,562.35
393	Биет бус хөрөнгө	47,298,000.00	57,298,000.00
39301	Программ хангамж	740,000.00	740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-740,000.00	-740,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,298,000.00	57,298,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,407,083,287.27</u>	<u>1,436,449,355.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>29,863,465.12</u>	<u>39,549,537.14</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>29,863,465.12</u>	<u>39,549,537.14</u>
41300	Өглөг	<u>29,836,465.12</u>	<u>39,549,537.14</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	<u>9,327,465.12</u>	<u>0.00</u>
4136	Бусад өглөг	<u>20,536,000.00</u>	<u>39,549,537.14</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	<u>20,536,000.00</u>	<u>39,549,537.14</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,377,219,813.15</u>	<u>1,396,899,818.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,377,219,813.15</u>	<u>1,396,899,818.76</u>

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	574,938,161.15	574,938,161.15
51101	Өмч: - төрийн	574,938,161.15	574,938,161.15
512	Хуримтлагдсан үр дүн	299,498,847.65	505,243,181.26
51210	Өмнөх үеийн үр дүн	299,498,847.65	485,563,175.65
51220	Тайлант үеийн үр дүн		19,680,005.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	502,782,804.35	316,718,476.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,407,083,278.27</u>	<u>1,436,449,355.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,899,525,155.60	2,500,111,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,535,755.60	231,035,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,535,755.60	231,035,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	39,418,025.00	169,881,464.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	5,815,330.60	60,809,835.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	302,400.00	344,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,853,989,400.00	2,269,075,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,662,024,400.00	2,043,877,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,662,024,400.00	2,043,877,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	191,965,000.00	225,198,200.00
131105	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	191,965,000.00	225,198,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,998,379,677.60	2,405,412,545.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,998,379,677.60	2,405,412,545.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,941,875,280.93	2,331,484,795.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,329,069,144.03	1,615,471,313.81
210101	Үндсэн цалин	847,781,574.65	878,459,175.15
210102	Нэмэгдэл	416,840,519.90	618,950,501.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт		45,399,151.81
210104	Урамшуулал	64,447,049.48	72,662,485.77
2102	Ажил олгогчроос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,224,564.37	201,095,548.77
210201	Тэтгэврийн даатгал	113,586,281.47	137,773,230.13
210202	Тэтгэмжийн даатгал	13,403,740.95	16,208,509.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,363,561.67	9,144,392.65
210204	Ажилгүйдлийн даатгал	6,174,196.08	7,328,415.08
210205	Эрүүл мэндийн даатгал	24,696,784.20	30,641,001.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,305,123.33	185,436,860.14
210301	Гэрэл, цахилгаан	8,930,083.81	16,069,020.62
210302	Түлш, халаалт	168,655,039.52	168,655,039.52
210303	Цэвэр, бохир ус	720,000.00	712,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,282,500.00	20,252,582.00
210401	Бичиг хэрэг	3,944,850.00	3,486,572.00

210402	Тээвэр, шатахуун	11,251,700.00	12,309,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,085,950.00	4,456,300.00
2105	Нормативт зардал	71,643,260.00	117,321,985.00
210502	Хоол, хүнс	71,643,260.00	116,821,985.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,968,000.00	2,790,000.00
210604	Урсгал засвар	9,968,000.00	2,790,000.00
2107	Томилолт, зочны зардал	812,000.00	
210702	Дотоод албан томилолт	812,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,453,064.45	23,231,186.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,400.00	344,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,150,664.45	22,887,086.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,117,624.75	165,885,319.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,109,666.00	10,704,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,789,300.00	11,474,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,218,658.75	143,705,919.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,504,396.67	73,927,750.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,194,520.00	73,927,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	46,191,720.00	73,927,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,002,800.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн Захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,309,876.67	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,309,876.67	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-98,854,522.00</u>	<u>94,698,754.92</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		75,018,749.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		75,018,749.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-75,018,749.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-98,854,522.00</u>	<u>19,680,005.61</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,854,291,800.00	2,269,420,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	302,400.00	344,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,853,989,400.00</u>	<u>2,269,075,900.00</u>
1310	Улсын төсвөөс	1,662,024,400.00	2,043,877,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,662,024,400.00	2,043,877,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	191,965,000.00	225,198,200.00
131105	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	191,965,000.00	225,198,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,860,954,527.73</u>	<u>2,318,288,881.02</u>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,860,954,527.73	2,318,288,881.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,802,686,271.06	2,248,418,581.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,319,741,678.91	1,625,278,346.15
210101	Үндсэн цалин	838,454,109.53	888,266,207.49
210102	Нэмэгдэл	416,840,519.90	618,950,501.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт		45,399,151.81
210104	Урамшуулал	64,447,049.48	72,662,485.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,224,564.37	201,095,548.77
210201	Тэтгэврийн даатгал	113,586,281.47	137,773,230.13
210202	Тэтгэмжийн даатгал	13,403,740.95	16,208,509.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,363,561.67	9,144,392.65
210204	Ажилгүйдлийн даатгал	6,174,196.08	7,328,415.08
210205	Эрүүл мэндийн даатгал	24,696,784.20	30,641,001.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	178,305,123.33	152,408,200.00
210301	Гэрэл, цахилгаан	8,930,083.81	16,069,020.62
210302	Түлш, халаалт	168,655,039.52	135,626,379.82
210303	Цэвэр, бохир ус	720,000.00	712,800.00
2105	Нормативт зардал	71,281,640.00	115,963,500.00
210502	Хоол, хүнс	71,281,640.00	115,963,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,350,000.00	72,790,000.00
210604	Урсгал засвар	9,350,000.00	72,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,158,664.45	23,231,186.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,400.00	344,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,856,264.45	22,887,086.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,624,600.00	57,651,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,135,300.00	49,861,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,849,300.00	7,789,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,268,256.67	69,870,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,958,380.00	69,870,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	47,955,580.00	69,870,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,002,800.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,309,876.67	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,309,876.67	
III	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-6.662.727.73	-48.868.881.02
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,489,900.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,489,900.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	26,489,900.00	

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,489,900.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-26,489,900.00	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-33,152,627.73	-48,868,881.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,493,421.52	89,340,793.79
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89,340,793.79	40,471,912.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээх үлдэгдэл	574,938,161.15	504,051,100.02	508,233,086.11	1,587,222,347.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,268,295.67	1,268,295.67
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,938,161.15	504,051,100.02	509,501,381.78	1,588,490,642.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			-1,517,601.61	-1,517,601.61
C08	2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	574,938,161.15	502,782,804.35	299,498,847.65	1,377,219,813.15

D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	574,938,161.15	502,782,804.35	299,498,847.65	1,377,219,813.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			186,064,328.00	186,064,328.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	574,938,161.15	502,782,804.35	485,563,175.65	1,563,284,141.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-186,064,328.00		-186,064,328.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			19,680,005.61	19,680,005.61
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	574,938,161.15	316,718,476.35	505,243,181.26	1,396,899,818.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,174,182,700.00	2,093,090,681.02	81,092,018.92	96.3%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,174,182,700.00	2,093,090,681.02	81,092,018.92	96.3%
210	Бараа, үйлчилгээний зардал	2,103,128,800.00	2,203,220,381.02	79,908,418.98	96.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,686,509,500.00	1,625,278,346.15	61,231,153.85	96.4%
210101	Үндсэн цалин	1,008,142,100.00	888,266,207.49	119,875,892.51	88.1%
210102	Нэмэгдэл	629,740,200.00	618,950,501.08	10,789,698.92	98.3%
210103	Унаа, болон бусад нөхөн олговор		45,399,151.81	-45,399,151.81	
210104	Урамшуулал	48,627,200.00	72,662,485.77	-24,035,285.77	149.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,813,500.00	201,095,548.77	9,717,951.23	95.4%
210201	Тэтгэврийн даатгал	143,353,300.00	137,773,230.13	5,580,069.87	96.1%
210202	Тэтгэмжийн даатгал	16,865,100.00	16,208,509.12	656,590.88	96.1%
210203	ҮОМШӨ ний даатгал	8,432,500.00	9,144,392.65	-711,892.65	108.4%

210204	Ажилгүйдлийн даатгал	8,432,500.00	7,328,415.08	1,104,084.92	86.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	33,730,100.00	30,641,001.79	3,089,098.21	90.8%
2105	Нормативт зардал	115,963,500.00	115,963,500.00		100%
210502	Хоол, хүнс	115,963,500.00	115,963,500.00		100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	23,499,800.00	23,231,186.10	268,613.90	98.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,100.00	344,100.00		100%
210806	Мэдээллийн технологийн зардал	23,155,700.00	22,887,086.10	268,613.90	98.8%
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	66,342,500.00	57,651,800.00	8,690,700.00	86.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,261,600.00	49,861,900.00	8,399,700.00	85.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	8,080,900.00	7,789,900.00	291,000.00	96.4%
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,053,900.00	69,870,300.00	1,183,600.00	98.3%
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,053,900.00	69,870,300.00	1,183,600.00	98.3%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,053,900.00	69,870,300.00	1,183,600.00	98.3%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,082,628,200.00	2,044,221,800.00	38,406,400.00	98.2%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,082,325,800.00	2,043,877,700.00	38,406,400.00	98.2%
	Үндсэн үйл ажиллагааны орлого	302,400.00	344,100.00	-41,700.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		89,340,793.79	-89,340,793.79	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		40,471,912.77	-40,471,912.77	

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,198,200.00	225,198,200.00		100%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	225,198,200.00	225,198,200.00		100%
210	Бараа, үйлчилгээний зардал	225,198,200.00	225,198,200.00		100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,408,200.00	152,408,200.00		100%
210301	Гэрэл, цахилгаан	18,457,900.00	16,069,020.62	2,388,879.38	87.1%
210302	Түлш, халаалт	133,237,500.00	135,626,379.38	-2,388,879.38	101.8%
210303	Цэвэр, бохир ус	712,800.00	712,800.00		100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,790,000.00	72,790,000.00		100%
210604	Урсгал засвар	72,790,000.00	72,790,000.00		100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,198,200.00	225,198,200.00		100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,198,200.00	225,198,200.00		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа, зорилго, зорилт

Малчин сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын болон татварын багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хууль, Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,366.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	89,340.8	40,471.9	-48,868.9
Авлага		479.5	479.6
Урьдчилгаа			
Бараа материал	51,543.5	108,142.1	56,598.6
Үндсэн хөрөнгө	1,266,199.0	1,287,355.8	21,156.8
Нийт хөрөнгө	1,407,083.3	1,436,449.3	29,366.1
Өр төлбөр	29,863.4	39,549.5	9,686.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,377,219.8	1,396,899.8	19,680.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,407,083.3	1,436,499.3	29,366.1

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 40,471.9 мянган төгрөг болж 48,868.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 479.6 мянган төгрөг байгаа нь хувь хүмүүсээс авах авлага үүссэн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 108,142.1 мянган төгрөг болж 56,598.6 мянган төгрөгөөр өсөхөд аж ахуйн материалын өсөлт гол нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,287,355.8 мянган төгрөг болж 21,156.8 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар авсан тоног төхөөрөмжийн болон тавилга хэрэгслийн өсөлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан барилгын өсөлттэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 39,549.5 мянган төгрөг болж 9,686.1 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилт дутуу ирснээс үүссэн байгууллагад төлөх халаалт, шатахуун, хүнсний өр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,396,899.8 мянган төгрөг болж 19,680.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 600,586.1 мянган төгрөгөөр буюу 31.6 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 185,457.9 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого 415,128.2 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 407,032.9 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар өссөн байна. Зарлага өсөхөд цалингийн зардлын өсөлт болон элэгдлийн зардал голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,388,715.6 мянга, орон нутгийн төсвөөс 241,162.2 мянга, нийт зарлагыг 2,629,877.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 360,457.8 мянган төгрөгөөр бууруулж 2,269,420.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 129,960.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,399,380.9 мянган төгрөг болгон тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,043,877.7 мянга, орон нутгийн төсвөөс 225,198.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 344.1 мянга, нийт 2,269,420.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 89,340.8 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,318,288.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/мянган төгрөгөөр/ Биелэлт
1	80226	2,195.30	2,195.30		100%
2	80233	2,257.50	2,094.50	163.00	97.30%
3	80312	1,288.90	1,288.00	0.90	99.90%
4	81605	2,403.10	2,403.10		
5	81801	71,053.90	69,870.30	1,183,600.00	98.30%

6	81806	482,297.30	440,838.00	41,459.30	91.40%
7	81816	20,536.00	20,536.00	-	100%
8	81823	10,485.80	3,440.00	7,045.80	32.80%
9	81827	20,837.80	14,941.50	5,896.30	71.70%
10	81834	1,505,422.20	1,491,230.00	14,192.20	99.10%
11	81835	45,243.50	35,727.40	9,516.10	79%
12	81848	344.10	344.10	-	100%
13	81875	8,447.30	8,182.50	264.80	96.90%
14	83603	1,370.00	-	1,370.00	0.00%
15	80111	225,198.20	225,198.20	-	100%
		2,399,380.90	2,318,288.90	81,092.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл		740.0		Санхүүгийн Acolous, сургалтын программ
2	Унаа, хоолны зардал		47,525.0	47,525.0	Ажилтнуудад хоолны хөнгөлөлтийг 1 хоногт 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар		0.0		Зардал гараагүй.
4	Гадаад томилолт, арга хэмжээ		0.0		Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		0.0		Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол		0.0		Орон тооны цомхотгол хийгээгүй
7	Хэвлэл, мэдээлэл		0.0		Зардал гараагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Малчин сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд дотуур байрны хүүхдийн хоолны материал, үдийн хоолны материал нийлүүлэх худалдан авах ажиллагааг 5 багц болгон харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,998,379.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 19,983.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 15,987.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,405,412.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 24,054.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 19,243.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургууль нь Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 166, хугацаа хоцроож оруулсан 3, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайланд 10,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан болон Иж бүрэн байх, Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.
2. Санхүүгийн тайланд 479.6 мянган төгрөгийн авлага тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан болон Иж бүрэн байх, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр